



Г МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Бөхчүлүүны ПҮРЭВДОРЖ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-30-34, Факс: 26-30-34  
E-mail: purevdorj@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2004.03.22 № УХ-03/02291

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай Г

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Хамтын тэтгэврийн тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Б.ПҮРЭВДОРЖ

А.АДЬЯАСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Бөхчүлүүны ПҮРЭВДОРЖ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-30-34, Факс: 26-30-34  
E-mail: purevdorj@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2024.01.15 № УХА-05/360.

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Тов тогтоолгох тухай Т

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Хамтын тэтгэврийн тухай” хуулийн төслийг боловсруулсныг хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Б.ПҮРЭВДОРЖ

000005



Г МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Бөхчүүлүн ПУРЭВДОРЖ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-30-34, Факс: 26-30-34  
E-mail: purevdorj@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2020. 12. 03 № үзүүл-03/5912

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Хуулийн төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Хамтын тэтгэврийн тухай” хуулийн төслийг боловсрууллаа. Иймд уг хуулийн төсөлд хуульд заасны дагуу саналаа ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Б.ПУРЭВДОРЖ

000416

БАТЛАВ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Б.ПҮРЭВДОРЖ

ХАМТЫН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Төрөөс иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь нийгмийн даатгалыг боловсронгуй болгох, тэр дундаа Монгол орны онцлогт тохирсон тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг боловсронгуй болгох явдал юм.

Монгол улс дахь тэтгэврийн асуудлыг Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулдаг ба тэтгэврийн даатгалын сан нь дотроо өндөр настан, тахир дутуу, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, тэтгэмжээс бурдаж байна. Манай улсын одоогийн тэтгэврийн тогтолцооны тэтгэвэр бодох арга нь төлсөн шимтгэлтэйгээ шууд хамааралгүйгээс хуваарилалт шударга бус, хувь хүний тэтгэврийн даатгалын сангийн хөрөнгийг үнэгүйдүүлж, эдийн засгийн шинэчлэл, хөрөнгийн зах зээлийн хөгжилтэй уялдуулж зохицуулаагүйгээс тэтгэврийн даатгалын санд сөрөг үр дагаврууд бий болсоор байгаа юм.

Манай улс Тэтгэврийн даатгалын өнөөгийн тогтолцоог хагас хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх, "Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс"-ны аргыг хэрэглэх хамгийн нааштай хувилбарыг сонгон ажиллаж байгаа боловч 1960 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойш төрсөн хүмүүсийн ажилласан бүх хугацаанд төлсөн байвал зохих шимтгэлийг нэрийн дансанд байршуулсан мөнгөн хуримтлал байхгүй байна.

Нийгмийн даатгалд төлсөн шимтгэлээ хуримтлалын зарчмаар өсгөж тэтгэвэртээ гарахад бүрэн эргүүлэн авах иргэдийн хүсэл, сонирхлыг хөхүүлэн дэмжих, нийгмийн даатгалын хуримтлалыг эдийн засгийн оновчтой бодлогоор арвижуулах, нийгмийн шударга хуваарилалтыг баталгаажуулах нь төрийн бодлогын гол зорилго байх ёстой.

Тэтгэврийн даатгалын тогтолцоонд тэтгэвэрт гарч байгаа иргэдийн насны бүтэц, дундаж наслалтын хэтийн төлөвийг харгалзан үзэх хэдий ч Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ... иргэнийхээ өмнө Төр хариуцна." гэж заасны дагуу цаашид тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээ, хуримтлалын тогтолцоог өөрчлөх бодлого барьж ажиллах хэрэгцээ шаардлага бий болсон.

Өмнө нь төрөөс тэтгэврийн тогтолцооны асуудлыг зөв тодорхойлох, нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлалыг бий болгох, шударга хуваарилалтын зарчмыг

хэрэгжүүлэх зорилтын хүрээнд тэтгэврийн зөрүүг арилгах, өөрөөс үл хамаарах шалтгааны улмаас нийгмийн даатгалын шимтгэл төлж чадаагүй иргэдийн асуудлыг нэг удаагийн арга хэмжээгээр зохицуулах зэрэг иргэдрүүгээ чиглэсэн олон нааштай арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хэдий ч бас төрөөс зайлшгүй зохицуулах шаардлагатай зарим асуудал байсаар байна. Энэ нь "Хамтын тэтгэврийн" асуудал юм. Хамтын тэтгэврийн асуудал нь дараах хэд хэдэн онцлогийг агуулна. Үүнд:

1. Зарим улс орон төдийгүй манай улсад олон жил хамт амьдарсан нэг гэр бүлийн хоёр буурлын нэг нь хорвоогийн мөнх бусыг үзүүлэхэд үлдэж байгаа буурал нь цаг хугацааны хувьд удаан амьдарч чадахгүй байгаа статистик судалгаа байдаг байна. Энэ нь өрхийн амьжиргааны хэрэглээ буурах, ганцаардах, сэтгэл санааны уналтад орох, хөгшрөлтийн процесс хурдан явагдах зэрэг сөрөг байдлаар илэрдэг байна. Үүнээс сэргийлэх зорилгоор "хамтын тэтгэврийн" асуудлыг цаашид бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй юм.

2. Монгол Улсад хамтын тэтгэврийн тухай хууль үйлчилснээр цаашид тогтвортой гэр бүлийн тоо нэмэгдэх, гэр бүлийн гишүүдийн бие биеэ хайрлах, урт удаан хугацаанд хамт амьдрах, олон хүүхэд төрүүлж өсгөх, эрүүл мэнддээ анхаарах зэрэг олон чухал ач холбогдолтой болно.

Хамтын тэтгэврийн тухай хуулийн гол үзэл санаа нь хуулийн төсөлд зааснаар олон жил хамт амьдарсан гэр бүлийн гишүүдийн нэг нь нас барсан тохиолдолд үлдсэн гэр бүлийн гишүүнд нь түүний амьдрах хугацаанд нь тэтгэвэр нь тодорхой хувь хэмжээгээр давхар олгогдох явдал юм. Гэхдээ хуульд заасан тодорхой шаардлагыг байгаагүй иргэд энэ хуульд хамрагдахгүй юм. Хамтын тэтгэврийн тухай хуулийг Тэжээгчээ алдсаны тэтгэврийн тухай хуультай адилтган ойлгож болохгүй юм.

### **Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нэг бүлэг 10 зүйлтэй. Хуулийн төсөлд хуулийн үйлчлэх хүрээ, хамрагдах субъектүүд, тэтгэврийг хэнд олгох, хэрхэн тооцох талаар, давхар тэтгэврийн хэмжээ, олгох хугацаа, бүрдүүлэх баримт, хариуцлага зэргийг тусгасан.

Энэ хуулийн зорилт нь нийгмийн даатгалын сангаас өндөр насны болон цэргийн алба хаасны бүрэн тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний эхнэр эсхүл нөхөрт авч байсан тэтгэврийг нь үргэлжлүүлэн олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хамтын тэтгэвэр авах эрх үүссэн иргэнд олгох хамтын тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшин, үнэ ханшны өөрчлөлттэй уялдуулан Засгийн газар жил бүр тогтоох бөгөөд хамтын тэтгэвэр нь нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээний 30 хувиас багагүй байхаар хуулийн төсөлд тусгасан.

### **Гурав. Хамтын тэтгэврийн тухай хууль батлагдсанаар үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагаврын талаар**

Гэр бүлийн өндөр настан хамтдаа тэтгэвэр авч байгаад нэг нь нас барах тохиолдолд үлдэж байгаа ганц бие ахмад настан нэг хүний тэтгэврээр амжиргаагаа

залгуулахад хүндрэлтэй болдог. Түлээ нүүрс, орон сууц, ус, байр, цахилгааны төлбөр нь хоёулаа байх үетэй ижил өртөгтэй тогтмол гардаг зардлууд байдаг. Энэ нь ганц бие ёндөр настныг амжиргааны эрс доройтолд өртөхөөс сэргийлэх зорилготой нийгмийн хамгааллын арга хэмжээ юм.

Хамтын тэтгэврийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр цаашид тогтвортой гэр бүлийн тоо нэмэгдэх, эрүүл хамтдаа өтлөх болон ганц бие ахмад настны амжиргааны баталгаа хангагдах зэрэг олон ач холбогдолтой гэж үзэж байна

Монгол Улсад хамтын тэтгэврийн тухай хууль үйлчилснээр цаашид тогтвортой гэр бүлийн тоо нэмэгдэх, гэр бүлийн гишүүдийн бие биеэ хайлрах, урт удаан хугацаанд хамт амьдрах, олон хүүхэд төрүүлж өсгөх, эрүүл мэнддээ анхаарах зэрэг олон чухал ач холбогдолтой болно.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар**

Энэхүү хуулийн төслийг Үндсэн хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуультай нийцүүлэн боловсруулсан. Энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулна.

--- оОо ---

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .... дугаар  
сарын...-ны өдөр

Улаанбаатар хот

### ХАМТЫН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь нийгмийн даатгалын сангаас өндөр насы болон цэргийн алба хаасны бүрэн тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний эхнэр эсхүл нөхөрт авч байсан тэтгэврийг нь үргэлжлүүлэн олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Хамтын тэтгэврийн тухай хууль тогтоомж

2.1. Хамтын тэтгэврийн тухай хууль тогтоомж нь Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно:

3.1.1. “гэрлэгчид” гэж Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэгт заасныг;

3.1.2. “нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насы тэтгэвэр” гэж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 5-д заасан болзлыг хангасан иргэний авч байгаа өндөр насы тэтгэврийг;

3.1.3. “цэргийн алба хаасны тэтгэвэр” гэж Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан болзлыг хангасан иргэний авч байгаа тэтгэврийг;

3.1.4. “10 ба түүнээс дээш жил хамт амьдарсан эхнэр, нөхөр” гэж гэрлэлтээ бүртгүүлээгүй эхнэр, нөхөр өндөр насы тэтгэвэр тогтоолгохоос өмнө 10 ба түүнээс дээш жил хамт амьдарсныг;

#### 4 дүгээр зүйл. Хамтын тэтгэвэр авах эрх

4.1. Энэ хуулийн үйлчлэлд дараах нөхцөлийг хангасан иргэн хамаарна:

4.1.1. нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насы тэтгэвэр эсхүл цэргийн алба хаасны тэтгэвэр авч байгаад нас барсан иргэний 10 ба түүнээс дээш жил хамт амьдарсан эхнэр эсхүл нөхөр;

4.1.2. хамтын тэтгэвэр авагч нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан тэтгэвэр авах эрх үүссэн Монгол Улсын иргэн байх.

4.2. Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насын тэтгэвэр авч байгаад нас барсан иргэний эхнэр эсхүл нөхөр нь энэ хуулийн 4.1.2-т заасан насандаа хүрээгүй тохиолдолд түүнд олговол зохих хамтын тэтгэврийг тухайн насандаа хүрсэн үед нь олгож эхлэх бөгөөд энэ эрх нь түүний эхнэр эсхүл нөхрийг нас барснаас хойш тав хүртэлх жилийн хугацаанд хадгалагдана.

4.3. Хамтын тэтгэврийг бусдад өвлүүлэхгүй.

#### **5 дугаар зүйл.Хамтын тэтгэврийн хэмжээ, олгох хугацаа**

5.1. Хамтын тэтгэвэр авах эрх үүссэн иргэнд олгох хамтын тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшин, үнэ ханшны өөрчлөлттэй уялдуулан Засгийн газар жил бүр тогтоох бөгөөд хамтын тэтгэвэр нь нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээний 30 хувиас багагүй байна.

5.2. Хамтын тэтгэвэр олгох хугацааны хамрах хүрээг Засгийн газар журмаар тогтооно.

5.3. Хамтын тэтгэврийг нас барсан эхнэр эсхүл нөхрийн өндөр насын тэтгэвэр авах хугацаа дуусгавар болсны дараа эхнэр эсхүл нөхөр нь хамтын тэтгэвэр авахыг хүсч өргөдөл гаргасан өдрөөс эхлэн олгоно.

5.4. Хамтын тэтгэвэр авагчийг нас барснаас хойш 30 хоногийг дуусталх хугацаанд хамтын тэтгэврийг олгоно.

5.5. Энэ хуулийн 4.1.1-д заасан иргэн 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгон авч байсан болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагч байсан бол түүний эхнэр эсхүл нөхөрт олгох тэтгэврийн зардлыг улсын төсвөөс хариуцна.

#### **6 дугаар зүйл.Хамтын тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг**

6.1. Хамтын тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн иргэн доор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяа нийгмийн даатгалын байгууллагад өгнө:

6.1.1. хамтын тэтгэвэр авахыг хүссэн иргэний маягтын дагуу гаргасан хүсэлт;

6.1.2. иргэний үнэмлэх, түүний хуулбар;

6.1.3. гэрлэлтийн гэрчилгээ, түүний нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;

6.1.4. хүсэлт гаргагчийн болон түүний нас барсан эхнэр эсхүл нөхрийн тэтгэврийн дэвтэр, түүний хуулбар;

6.1.5. эхнэр эсхүл нөхрийн нас барсны гэрчилгээ, түүний хуулбар;

6.1.6. оршин сууж байгаа газрын сум, хорооны Засаг даргын тодорхойлолт.

6.2. Хамтын тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн иргэн нь тэтгэврийн дэвтэргүй бол харьяа аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагаас түүнд шинээр тэтгэврийн дэвтэр олгоно.

#### **7 дугаар зүйл.Хамтын тэтгэврийг тогтоох, олгох тухай**

7.1. Хамтын тэтгэвэр олгох ажлыг нийгмийн даатгалын байгууллага зохион байгуулна.

7.2. Нийгмийн даатгалын байгууллагын аймаг, дүүргийн салбар нэгж, сумын байцаагч нь хамтын тэтгэвэр авахыг хүссэн иргэний хүсэлтийг энэ хуулийн 6.1-д заасан баримт бичгийн хамт хүлээн авна.

7.3. Нийгмийн даатгалын байгууллагын аймаг, дүүргийн салбар нэгж нь иргэний хүсэлтийг хүлээн авч, баримт бичгийн бурдэл хангагдсан гэж үзвэл хамтын тэтгэврийг олгох тухай шийдвэр гаргаж, хүсэлт гаргасан иргэний тэтгэврийн дэвтэрт тэмдэглэл хийнэ.

7.4. Хамтын тэтгэвэр авах эрх үүссэн иргэний бүрдүүлсэн баримт бичгийг тэтгэвэр авагчийн хувийн хэрэгт хавсаргаж, бүртгэлийн мэдээллийг нийгмийн даатгалын байгууллагын цахим санд байршуулна.

7.5. Хамтын тэтгэвэр авах эрх үүссэн иргэний тухай мэдээлэл, хамтын тэтгэврийн хэмжээ, тэтгэвэр олгох хугацаа, дуусгавар болоход нийгмийн даатгалын байгууллага хяналт тавьж ажиллана.

## **8 дугаар зүйл.Хамтын тэтгэврийг тогтоож олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулах**

8.1. Хамтын тэтгэврийг тогтоож олгохтой холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна.

## **9 дүгээр зүйл.Хариуцалга**

9.1. Хамтын тэтгэвэр тогтоолгоходоо хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, энэ хуулийг зөрчиж авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## **10 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

10.1. Энэ хуулийг 2020 оны .... дүгээр сарын ....-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

### **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйл дэх “Өндөр насны тэтгэвэр олгох хугацаа” гэх заалтыг бүхэлд нь хүчингүй болгосугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2020 оны .. дугаар сарын ..-ны өдөр баталсан Хамтын тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

### **ГАРЫН ҮСЭГ**

## ХАМТЫН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төрөөс тэтгэврийн тогтолцооны асуудлыг зөв тодорхойлох, нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлалыг бий болгох, шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд тэтгэврийн зөрүүг арилгах, өөрөөс үл хамаарах шалтгааны улмаас нийгмийн даатгалын шимтгэл төлж чадаагүй иргэдийн асуудлыг нэг удаагийн арга хэмжээгээр зохицуулах зэрэг иргэдрүүгээ чиглэсэн олон нааштай арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хэдий ч бас төрөөс зайлшгүй зохицуулах шаардлагатай зарим асуудал байсаар байна. Энэ нь “хамтын тэтгэврийн” асуудал юм. Хамтын тэтгэврийн асуудал нь дараах хэд хэдэн онцлогийг агуулна. Үүнд:

1. Бусад улс орон төдийгүй манай улсад олон жил хамт амьдарсан нэг гэр бүлийн хоёр буурлын нэг нь хорвоогийн мөнх бусыг үзүүлэхэд үлдэж байгаа буурал нь цаг хугацааны хувьд удаан амьдарч чадахгүй байгаа статистик судалгаа байдаг байна. Энэ нь өрхийн амьжиргааны хэрэглээ буурах, ганцаардах, сэтгэл санааны уналтанд орох, хөгшрөлтийн процесс хурдан явагдах зэрэг сөрөг байдлаар илэрдэг байна. Үүнээс сэргийлэх зорилгоор “хамтын тэтгэврийн” асуудлыг цаашид бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй юм.

2. Монгол улсад хамтын тэтгэврийн хууль үйлчилснээр цаашид тогтвортой гэр бүлийн тоо нэмэгдэх, гэр бүлийн гишүүдийн бие биээ хайрлах, урт удаан хугацаанд хамт амьдрах, олон хүүхэд төрүүлж өсгөх, эрүүл мэнддээ анхаарах зэрэг олон чухал ач холбогдолтой болно.

3. Хамтын тэтгэврийн тухай хууль бий болсноор тэтгэврийн хуримтлалын тогтолцоонд сэргеер нөлөөлөх байдал үүсэхгүй болно.

Хамтын тэтгэврийн тухай хуулийн гол үзэл санаа нь хуулийн төсөлд зааснаар олон жил хамт амьдарсан гэр бүлийн гишүүдийн нэг нь нас барсан тохиолдолд үлдсэн гэр бүлийн гишүүнд нь түүний амьдрах хугацаанд нь тэтгэвэр нь тодорхой хувь хэмжээгээр өвлөгдөх явдал юм. Гэхдээ хуульд зааснаар тодорхой шалгуурыг тавьж байгаа ч амьдрал баян учир зарим иргэнд уг хууль үйлчлэхгүй байх тохиолдол байна. Тухайлбал, хүнтэй суугаагүй боловч тэтгэвэр тогтоолгосон иргэн, насны хэт зөрөөтэй боловч хуульд заасан зарим шаардлагыг хангаж байгаа иргэн, улсад ажил, хөдөлмөр эрхлээгүй, нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаагүй иргэн Хамтын тэтгэврийн тухай хуульд хамрагдахгүй юм. Мөн түүнчлэн “Тэжээгчээ алдсаны тэтгэврийн тухай” хуультай адилтан ойлгож болохгүй юм. Тэжээгчээ алдсаны тэтгэврийн тухай хуулиар уг тэтгэврийг авах субъектүүдийг тодорхой заасан байдаг.

Гадаадын зарим улсын тэтгэврийн тогтолцоонд энэ чиглэлийн зохицуулалтын талаар судлахад хүн амын хөгшрөл хурдацтай нэмэгдэж байгаа Европын болон Өмнөд Америкийн олон орнуудад тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг туштай хэрэгжүүлсэн байдаг.

Зүүн европ, Скандинавын орнууд, Польш, Казахстанд гурван төвшинт тэтгэврийн тогтолцоонд, Өмнөд Америкийн Чили, Аргентин, Перу, Колумб зэрэг улсад цэвэр хуримтлалын тогтолцоонд шилжих алхмуудыг амжилттай хэрэгжүүлж байна.

Чили улсад тэтгэвэр авагч нас барвал хуримтлалын дансанд үлдсэн хэсгийг нь өвлүүлэх журам, Швед улсад тэтгэврийн даатгалын шимтгэлийн хуримтлалд байгаа үлдэгдлийг өв залгамжуулах журам, Итали улсад нас барсан этгээд Итали улсын авах эрх үүсдэг журам, Оросын Холбооны улсад тэтгэврийн нийт шимтгэл нь шимтгэл төлөгчийн нэрийн дансанд хуримтлагдаж тус дансанд ямар хэмжээний мөнгө хуримтлагдсан талаар ОХУ-ын тэтгэврийн сангаас ирээдүйн тэтгэвэр авагчид жил бүр “Аз жаргалын захидал” илгээн мэдээлдэг байдал, “Тэтгэврийн хуримтлалын хэсгийг хөрөнгө оруулалтаар эргэлтэнд оруулах тухай” хуульд “Өв залгамжлагчид нь даатгуулагч нас нөхчсөн өдрөөс хойш 6 сарын дотор ОХУ-ын Тэтгэврийн санд хандсан тохиолдолд төлбөр олгогдоно” гэж заасан, АНУлсад “Тэтгэвэр хамгаалах тухай хуулинд зааснаар гэр бүлийн эхнэр, нөхрийн аль нэг нь нас бараад тухайн цаг үеийнх нь эхнэр, эсвэл нөхөр нь тэтгэврийг нь шууд өвлөн авах эрх үүсдэг зэргээр улс орнууд өөрийн онцлогт тохирсон хамтын тэтгэврийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд “Гэрлэлт гэдэг нь харилцан эрх тэгш эрх, үүргийн үндсэн дээр эрэгтэй, эмэгтэй хүмүүс тодорхой ёслол, үйл ажиллагааны дунд сайн дурын бат холбоо тогтоож хуулиар батлуулах явдал юм” гэжээ. 2010 оны тооллогын дүнгээс үзэхэд Монгол Улсын нийт хүн амын 69.2 хувь /1905969 хүн/15 наснаас дээш насны хүн ам байна. Эдгээр хүмүүсийн 31.3 хувь нь огт гэр бүл болоогүй, 60.1 хувь нь гэр бүлтэй, 3.1 хувь нь салсан, 5.5 хувь нь бэлбэсэн хүн байна. Хуулийн төслийн шаардлагад нийцвэл зохих 10-аас дээш жил хамт амьдарсан, гэр бүлийн баталгаатай, дундаасаа үр хүүхэд төрүүлэн өсгөсөн гэр бүлийн тоог нарийвчлан гаргахад одоогийн байдлаар хүндрэлтэй байгаа хэдий ч хэрэв энэ хууль батлагдсаны дараа хуулийн шаардлагад нийцүүлэн тогтвортой гэр бүлийн тоог Улсын бүртгэлийн Ерөнхий газрын бүртгэлийн газартай хамтран иргэний регистрийн дугаараар гаргуулан авах бололцоотой юм. Харин бид ойролцоогоор хамтын тэтгэвэр авах бололцоотой иргэний тоог 76674 байхаар тооцоолж байгаа болно.

2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр УИХ-03/5912 тоот дугаартай засгийн газраас “Хамтын тэтгэврийн тухай” хуулийн төсөлд санал авах албан бичиг явуулсан. Хуулийн хугацаа болох ажлын 30 хоногт санал ирээгүй тул засгийн газраас өгөх санал байхгүй гэж үзэж байна.

Parliament.mn вэб сайтад байршуулсан “Хамтын тэтгэврийн тухай” хуулийн төсөлд нийт 69 хүн санал өгснөөс 66% нь дэмжинэ, 29% дэмжихгүй, 3% мэдэхгүй гэж санал өгсөн байна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

## **ХАМТЫН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**

Хамтын тэтгэврийн тухай хуулийн төслийн боловсруулалтыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан болно.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй нийцэж байна.

### **НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ**

Төрөөс тэтгэврийн тогтолцооны асуудлыг зөв тодорхойлох, нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлалыг бий болгох, шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд тэтгэврийн зөрүүг арилгах, өөрөөс үл хамаарах шалтгааны улмаас нийгмийн даатгалын шимтгэл төлж чадаагүй иргэдийн асуудлыг нэг удаагийн арга хэмжээгээр зохицуулах зэрэг иргэдрүүгээ чиглэсэн олон нааштай арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хэдий ч бас төрөөс зайлшгүй зохицуулах шаардлагатай зарим асуудал байсаар байна.

Тэтгэврийн даатгалын тогтолцоонд тэтгэвэрт гарч байгаа иргэдийн насны бүтэц, дундаж наслалтын хэтийн төлөвийг харгалзан үзэх хэдий ч Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ... иргэнийхээ өмнө Төр хариуцна." гэж заасны дагуу цаашид тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээ, хуримтлалын тогтолцоог өөрчлөх бодлого барьж ажиллах хэрэгцээ шаардлага байна.

### **ХОЁР. АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БУЙ УЧИР ШАЛТГААН**

Манай улсад олон жил хамт амьдарсан нэг гэр бүлийн хоёр буурлын нэг нь хорвоогийн мөнх бусыг үзүүлэхэд үлдэж байгаа буурал нь цаг хугацааны хувьд удаан амьдарч чадахгүй байгаа статистик судалгаа байдаг байна. Энэ нь өрхийн амьжиргааны хэрэглээ буурах, ганцаардах, сэтгэл санааны уналтанд орох, хөгшрөлтийн процесс хурдан явагдах зэрэг сөрөг байдлаар илэрдэг байна.

Нийгмийн даатгалд төлсөн шимтгэлээ хуримтлалын зарчмаар өсгөж тэтгэвэртээ гарахад бүрэн эргүүлэн авах иргэдийн хүсэл, сонирхлыг хөхүүлэн дэмжих, нийгмийн даатгалын хуримтлалыг эдийн засгийн оновчтой бодлогоор арвижуулах, нийгмийн шударга хуваарилалтыг баталгаажуулах нь төрийн бодлогын гол зорилго байх ёстой боловч энэ төрлийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчин манай улсад байхгүй байна.

## **ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Монгол улсад хамтын тэтгэврийн хууль үйлчилснээр цаашид тогтвортой гэр бүлийн тоо нэмэгдэх, гэр бүлийн гишүүдийн бие биеэ хайрлах, урт удаан хугацаанд хамт амьдрах, олон хүүхэд төрүүлж өсгөх, эрүүл мэнддээ анхаарах зэрэг олон чухал ач холбогдолтой болно.

2010 оны тооллогын дунгээс үзэхэд Монгол Улсын нийт хүн амын 69.2 хувь /1905969 хүн/15 наснаас дээш насын хүн ам байна. Эдгээр хүмүүсийн 31.3 хувь нь огт гэр бүл болоогүй, 60.1 хувь нь гэр бүлтэй, 3.1 хувь нь салсан, 5.5 хувь нь бэлбэсэн хүн байна. Хуулийн төслийн шаардлагад нийцвэл зохих 10-аас дээш жил хамт амьдарсан, гэр гаргахад одоогийн байдлаар хүндрэлтэй байгаа хэдий ч хэрэв энэ хууль батлагдсаны дараа хуулийн шаардлагад нийцүүлэн тогтвортой гэр бүлийн тоог Улсын бүртгэлийн Ерөнхий газрын бүртгэлийн газартай хамтран иргэний регистрийн дугаараар гаргуулан авах бололцоотой юм. Харин бид ойролцоогоор хамтын тэтгэвэр авах бололцоотой иргэний тоог 76674 байхаар тооцоолж байгаа болно.

Хамтын тэтгэврийн тухай хуулийн гол үзэл санаа нь хуулийн төсөлд зааснаар олон жил хамт амьдарсан гэр бүлийн гишүүдийн нэг нь нас барсан тохиолдолд үлдсэн гэр бүлийн гишүүнд нь түүний амьдрах хугацаанд нь тэтгэвэр нь тодорхой хувь хэмжээгээр өвлөгдөх явдал юм.

## **ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, зерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа:

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	өндөр насын болон цэргийн алба хаасны бүрэн тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний эхнэр эсхүл нөхөрт авч байсан тэтгэврийг нь үргэлжлүүлэн олгохтой холбогдсон харилцааг зохицуулах	Хуульд заасан шаардлага хангасан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч өндөр насын тэтгэвэрт гарсны дараа нас барсан тохиолдолд олгох хамтын тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгоно.
2	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хамтын тэтгэврийн тухай хуулийн төсөл боловсруулах	Зардал гарагчийн

**ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ  
ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

**ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
<b>1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх</b>	<b>1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</b>			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	<b>1.2. Оролцоог хангах</b>			
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		Шударга ёсны зарчимд нийцсэн
	1.2.2. Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдэж буй, эсхүл хөндөгдэж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Шударга ёсны зарчимд нийцнэ
	<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл,

	эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх			боловжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	энэ асуудалтай холбогдолгүй
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	Хуулийн зорилго, шударга ёсонд нийцсэн
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Шаардлагагүй
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

### ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

болов захиргааны зардал	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5. Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4. Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1. Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Өмчлөх эрх	5.1. Өмчлөх эрхийг (ул хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2. Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3. Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1. Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2. Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	үзүүлэх эсэх			
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Зардал гарагчгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарагчгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй
10.Макро здийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарагчгүй.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарагчгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Ямар нэгэн байдлаар зөрчилдэхгүй. Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

#### НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарагчгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарагчгүй

	1.4. Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1. Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3. Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4. Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5. Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1. Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2. Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарагчий
	4.3. Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарагчий
	4.4. Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарагчий
5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1. Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас бааралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарагчий
	5.2. Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	үзүүлэх эсэх			
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх явц сайжирч, зэрэг нөлөө гарна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

# **ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Энэхүү хуулийн төсөл боловсруулахдаа бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг судлаж үзсэн. Тухайлбал,

Чили улсад тэтгэврийг олгоходоо насан туршдаа тэтгэвэр авах, хуримтлагдсан нийт мөнгөнөөс төлөвлөгөөтэйгөөр хасалт хийж авахын аль нэгийг сонгох эрх олгодог бөгөөд төлөвлөгөөтэйгөөр хасалт хийж авах хувилбарыг сонгосон тохиолдолд даатгуулагч болон тэтгэвэр авагч нас барвал хуримтлалын дансанд үлдсэн хэсгийг нь өвлүүлэх журамтай байдаг байна.

Швед улсад тэтгэврийн даатгалын шимтгэлийн хуримтлалд байгаа үлдэгдлийг өв залгамжлуулах журамтай. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хуримтлалын хэсгийн үлдэгдлийг өвлүүлэхдээ түүний нас чацуу, тэтгэврийн насанд хүрсэн иргэдэд тарааж хуваарилдаг бөгөөд энэ нь тэдгээрийн авах тэтгэврийн хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлдэг байна.

Итали улсад нас барсан этгээд Итали улсын иргэн бол түүний эхнэр /нөхөр/ иргэний харьяаллыг үл харгалзан тэтгэврийг нь өвлөн авах эрх үүснэ. Өвлөгдөх тэтгэврийн хэмжээг хуулиар тогтооно. Нас барсан даатгуулагч нэгээс дээш удаа гэрлэсэн бол тэдний хамтран амьдарсан хугацаанаас нь хамааруулж өвлөгдөх тэтгэврийг нь хуваах журамтай. Нас барсан этгээд гэрлэлт цуцлуулснаас хойш дахин гэрлээгүй бөгөөд түүнээс тэтгэмж авах эрхтэй салсан гэр бүлийнхний амьжиргааны байдал нь хүнд байгаа бол тэтгэврийг тэдэнд өвлүүлэх эсэх асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэх журамтай.

Оросын Холбооны улсад тэтгэврийн нийт шимтгэл нь шимтгэл төлөгчийн нэрийн дансанд хуримтлагдаж тус дансанд ямар хэмжээний мөнгө хуримтлагдсан талаар ОХУ-ын тэтгэврийн сангаас ирээдүйн тэтгэвэр авагчид жил бүр “Аз жаргалын захидал” илгээн мэдээлдэг байна. Тэтгэврийн шимтгэл төлөгч нь өөрийн нэрийн дансан дахь хуримтлалаа зөвхөн тэтгэвэрт гарсныхаяа дараа ашиглах боломжтой ба харин хуульд зааснаар шимтгэл төлөгч иргэн тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхээсээ өмнө нас нөхөцсөн тохиолдолд түүний нэрийн дансанд хуримтлагдсан мөнгийг өв залгамжлагчид нь өвлөх эрхтэй байна. “Тэтгэврийн хуримтлалын хэсгийг хөрөнгө оруулалтаар эргэлтэд оруулах тухай” хуульд “Өв залгамжлагчид нь даатгуулагч нас нөгчсөн өдрөөс хойш 6 сарын дотор ОХУ-ын Тэтгэврийн санд хандсан тохиолдолд төлбөр олгогдоно” гэж заасан.

АНУлсад “Тэтгэвэр хамгаалах тухай хуулинд зааснаар гэр бүлийн эхнэр, нөхрийн аль нэг нь нас барагад тухайн цаг үеийнх нь эхнэр, эсвэл нөхөр нь тэтгэврийг нь шууд өвлөн авах эрх үүсдэг байна.

## **I. Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага**

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хууль тогтоомжийн тухай хууль;

## **ХАМТЫН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

### **НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Энэхүү үнэлгээг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн боловсруулсан “Хамтын тэтгэврийн тухай” хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэсэн.

Үнэлгээ хийх хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т заасан Анхдагч хуулийн төрлөөр боловсруулагдсан хувилбар байв. Хуулийн төсөл нь 10 зүйлээс бүрдэж байна.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу хийлээ.

Хамтын тэтгэврийн тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал” - /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийсэн.

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

### **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд заасны дагуу 6 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь анхадгч хуулийн төсөл тул түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд болон хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой боловсруулагдсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс үнэлэхийг зорьж сонголоо.

**“Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд болон хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо нийцсэн эсэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг шалган тогтоож, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултуудад хариулах замаар үнэлэхээр сонгосон болно.

## **ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

**“Зорилгод хүрэх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийв.

Хуулийн төслийг боловсруулахдаа нэг бүлийн өндөр настнуудын хэн нэг нь нас барсан тохиолдолд үлдэж байгаа эхнэр эсвэл нөхөрт хамтын тэтгэврийг олгох асуудлын тухай тусгасан байна.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийн ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

/ Хуулийн төсөл 10 зүйлтэй./

**“Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

/Хуулийн төсөл 10 зүйлтэй./

## **ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгах байдлаар <b>ойлгомжтой байдлыг шалгах.</b>
3	Харилцан уялдаатай байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу Хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

### **“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хамтын тэтгэврийн тухай хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тооцон судлах, хуулийн төслийн зохицуулалт нь тухайн төслийн зорилго, зорилтод хүрэх боломжтой байдлаар томьёологдсон байна.

Хуульд заасан шаардлагыг бүрэн хангасан нэг гэр бүлийн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмадуудын нэг нь нас барсан тохиолдолд үлдсэн эхнэр эсвэл нөхөрт нь хуульд заасан хувь хэмжээ, хугацаагаар нас барсан эхнэр эсвэл нөхрийн авч байсан тэтгэврийг өвлүүлэн өгөх бүрэн боломжтой буюу энэ зорилго биелэх боломжтой юм.

### **“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хамтын тэтгэврийн тухай хуулийн үйлчлэх хүрээ, хамрах байдал, хэрэгжүүлэх эрх бүхий этгээд, хэн ямар шаардлага хангасан байх, хэзээ, ямар хэмжээтэй олгох гээд зохицуулалт бүрэн ойлгомжтой байна.

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилгүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлага хангасан.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар	Шаардлага хангасан.

зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

**“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараахь стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорьлоо.

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
2	хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
3	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.
5	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардсан зүйлгүй.
6	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.
7	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
8	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй.
9	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	хуулийн төсөлд татвар, төлбөр хураамжийн асуудал тусгагдаагүй.
10	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй	хуулийн төсөлд аж

	холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
12	хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Шаардлага хангасан
13	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
14	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
15	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн хуулиар зохицуулна.

-----oOo-----

## ХАМТЫН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ СУДАЛГАА

Хамтын тэтгэврийн тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьж, холбогдох байнгын хорооны түвшинд хэлэлцэгдэж байна. Энэхүү хуулийн төсөлд 10 жил хамт амьдарч, шимтгэл төлж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлд заасны дагуу өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн эхнэр, нөхрийн аль нэг нь нас барвал тухайн авч байсан тэтгэврийг үргэлжлүүлэн амьдрах хугацаандaa авахаар тусгасан болно.

Энэ хуулийн үйлчлэлд хамрагдах тэтгэвэр авагчийн тоо, түүнд шаардлагатай хөрөнгийн судалгааг Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн тооцлоо.

	Жилд барсан тэтгэвэр авагчдын тоо <i>/судалгаагаар/</i>	нас	Дундаж тэтгэвэр	1 сард	жилд	Тэтгэврийн 20 хувь
Эхний жил	10200	386.000	3,937,200.000	47,246,400.000	9,449,280.000	
2 дахь жил	20150	386.000	7,758,600.000	93,103,200.000	18,620,640.000	
3 дахь жил	30100	386000	11,618,600.000	139,423,200.000	27,884,640.000	
Нийт дүн				279,772,800.000	55,954,560.000	

Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сангийн 2018 оны мэдээллээс үзэхэд 60-аас дээш настай эрэгтэй 95 075, 55-аас дээш настай эмэгтэй 17 6614, нийт **271 689** иргэд нэг хаяган дээр амьдарч байгаа судалгаа байна.

Үүнээс нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авдаг 60-аас дээш настай эрэгтэй 32 742 өндөр настан байгаа бөгөөд тэдний дундаж тэтгэвэр 398 603 төгрөг, 55-аас дээш настай эмэгтэй 34 280, тэдний дундаж тэтгэвэр 290 356 төгрөг, бөгөөд нийтдээ **67 022** тэтгэвэр авагч нэг хаяг дээр амьдарч байна. Эдгээр тэтгэвэр авагчийн дундаж тэтгэвэр **344 480** төгрөг байна.

Харин жилдээ дундажаар 10.0 гаруй тэтгэвэр авагч нас бардаг, эдгээр иргэдийн дундаж тэтгэвэр судалгаанаас үзэхэд 386 151.2 төгрөг болж байна.

Хамтын тэтгэврийн тухай хуулийн төслийн хүрээнд тэтгэврийг 20 хувь олгоно гэж 2018 оны тоо мэдээлэлд үндэслэн тооцвол нийтдээ тэтгэврийн сангаас 9.5 тэрбум төгрөгийн зардал гарахаар тооцлоо. Хэрэв гурван жилээр тооцож үзвэл нийтдээ 56 тэрбум төгрөг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

Харин Хамтын тэтгэврийн тухай хуулийн төслийн хүрээнд 2021 оны төсвийн төслийг тооцон үзэхдээ 2018 онд нас барсан тэтгэвэр авагчийн тоог 5 хувиар, тэтгэврийн хэмжээг 10 хувиар тус тус өснө гэж тооцон, тэтгэврийг 100 хувиар тооцон олгоход 36.4 тэрбум, 80 хувиар тооцоход 29.1 тэрбум, 70 хувиар тооцоход 25.5 тэрбум, 60 хувиар тооцоход 21.8 тэрбум, 50 хувиар тооцоход 18.2 тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардлагатай гэсэн урьдчилан тооцоо хийв.

Төмөрөрүүлэх барилгын - айнүүдэг | X | (4) Facebook | X | (4) Facebook | X | (4) Not secure | forum.parliament.mn/projects/10985

Apps | cover | YouTube | (6772 views) - аяа... | GoGo Share | (6521 views) - аяа... | Mahan Care | Alm... | (8210 views) - аяа... | Search | Google | (1) Search | Файл 105.5 МБНГДЛ ...

ЦАХЛЫМ ХЭЛЭЛЦҮҮГҮҮЗИ

Халдсан

## ХАМТЫН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ

Байгаль нийтийн хөгжлийн төслийн үзэл барьжтлын эсэх	Нэгдсэн хуралдааны төслийн үзэл	Байгаль нийтийн хөгжлийн төслийн үзэл	Нэгдсэн хуралдааны төслийн үзэл
Хорогтоор төслийн үзэл барьжтлын эсэх	Хорогтоор төслийн үзэл барьжтлын эсэх	Хорогтоор төслийн үзэл барьжтлын эсэх	Хорогтоор төслийн үзэл барьжтлын эсэх

### Төслийн файлыг татах

#### ТӨСЛИЙН ХАВСРАЛТУД

1. Үзэл барьжтлал
2. Таницуулга
3. Судалгаа, павлагaa, тооцоо, бусад мэдээлэл

#### ТӨСӨЛ САНААЧЛАГЧИД

#### ПУРЭВДОРЖ БӨХЧУУЛНЫ

Дагасан (0) | Уснын (69) | Санал (0)

Нийтэсэн хэлэлцүүгийн хөтөн

Огноо: 2020-1-26

Та санал огихийн туда нийтрэх шаардлагатай!

#### Санал огихийн туда нийтрэх шаардлагатай

ИДДИЕРГИЙН ЭЗИССЭГТЭН

- Монгол Улсын Үндсэн хуульд оруулж нэмээлт, бөрчлөлийн төслийн төслийн үзэл
- Төрийн төмөнгийн тухай хуулийн шинжчинсээний нийтийг
- Цагдаагийн албаны тухай
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нариж, түүний удирдлагын тухай / Шинжчинсэн нийтийг
- ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮҮНИЙ БАЙДЛЫН ТУХАЙ / Шинжчинсэн нийтийг

#### ЕРӨНХИЙ ЗҮҮЛГИЙН ХЭСГЭГ, ЗААЛААР

Type here to search

Монгол Улсын Үндсэн хуульд оруулж нэмээлт, бөрчлөлийн төслийн төслийн үзэл

X | (4) ENG | 3:04 PM | 1/15/2021